

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Мандалын голын төмөр бетон гүүр /Баянхонгор, Галуут сум/ төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Тендер шалгаруулалтын дугаар: ЗТХЯ/201801012

Зам, тээврийн хөгжлийн яам нь Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт дахь XIV.1.1.36 Мандалын голын төмөр бетон гүүр /Баянхонгор, Галуут сум/ төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулагдана.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50.000 (Тавин мянга) төгрөгөөр цахимаар худалдаж авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.
- Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудын аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж гүйцэтгэсэн байна. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.
- Тендерийн хамт 10.0 сая төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.
- Төмөр бетон гүүр барих тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 14.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 14.30 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн талаарх нэмэлт мэдээллийг доорх хаягаар авч болно. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын байр 13, Зам, тээврийн хөгжлийн яам 401 тоот, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Д.Оюунбилэг, Утас-62263207, факс-11312315